


ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ДАРХАН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2024 ОНЫ ХАРУУЛ  
ХАМГААЛАЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.03.20

Д/Д	Үзүүлэлт	Үр дүн
1	Байршил буюу объект:	1. Харуул хамгаалалтын үйлчилгээ явуулах объектуудын ажлын бүдүүвч зураглал ирүүлэх.
2	Үндсэн ажил үүрэг:	2. Дархан Уул аймаг Дархан суманд харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулдаг объектуудаа эргэх зориулалтын машин /тусгай тоноглолтой байх/. 3. Өөрийн эзэмшлийн 2-оос доошгүй автомашинтай байх түүнийг гэрчлэх автомашины гэрчилгээний хувийг нотариатаар батлуулан ирүүлэх. 4. Харуул хамгаалалтын ажилчдад байх ёстой тоноглол багаж хэрэглэлийн жагсаалт тоо хэмжээ ирүүлэх. Үүнд: 4.1. Гав 4.2. Хантааз 4.3. Станц / Холбооны / 4.4. Газ 4.5. Цахилгаан ба Резин бороохой 4.6. Тусгай зориулалтын дүрэмт хувцас 5. Харуул хамгаалалтын албанд ажиллах хүчний тоо 25-с доошгүй байна. Нийт ажиллах хүчний ажлын туршлагын мэдээлэл, цахим үнэмлэхний хуулбар ирүүлэх. 6. Дархан Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг өөрийн хяналтын байртайг нотолсон гэрчилгээ, эсвэл түрээсийн байрны гэрээний хуулбарыг ирүүлэх. /Дархан-Уул аймагт төвтэй тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг бол давуу тал болно/ 7. Харуулын ажилчдыг хууль эрх зүйн болон холбогдох сургалтад хамруулсан байх, харуул хамгаалалтын алба хаагчаар 25 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, холбогдох сургалтад хамрагдсан, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулж (тухайн ажилтнуудыг захиалагч байгууллагын эрх бүхий ажилтанд танилцуулж мэдээллээр хангасан байх.) 8. Харуулын ажилчдыг сонгож авдаг шалгуур үзүүлэлтийг ирүүлнэ. 9. Удирдах болон инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.

		<p>10. Удирдах болон ахлах албан тушаалтнууд нь 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх. Нийт ажилчдын 20-аас доошгүй хувь нь Цагдаагийн байгууллагаас зохион байгуулдаг сургалтад хамрагдсан байх. Нотлох баримт ирүүлэх.</p> <p>11. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор: Одоо байгаа камерын болон дохиоллын системийг ашиглаж хамтран ажиллах.</p> <p>12. Цаг үеийн болон гамшгийн нөхцөл байдлын улмаас байгууллага хүн хүчний шаардлагатай тохиолдолд бие бүрэлдэхүүнийг дайчлан дэмжлэг үзүүлэх боломжтой байх</p> <p>13. Дархан Политехник Коллежийн 5 байршилд 24 цагаар тасралтгүй биечилсэн хамгаалалт хийх.</p> <p>14. Дархан Уул аймаг Дархан сум 13-р баг Оюутны хотхонд байрлах Хичээлийн 1, 2-р байр, дотуур байрууд, 5-р багт байрлах хичээлийн 3-р байрны барилга байгууламжуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, хорлон сүйтгэх гал түймэр, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх.</p> <p>15. Объектын дотор дэг журам алдагдуулсан үйлдэл гарч бусдын амь бие, эрүүл мэнд, эд зүйлд хохирол учирч болох нөхцөл үүссэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхээр гаднаас гэмт хэргийн шинжтэй халдлага үйлдсэн, хулгай, дээрэм, танхайн хэрэг зөрчил гарсан нь өөрөөр зогсоох боломжгүй бол таслан зогсоох зорилгоор мэргэжлийн тусгай хэрэгслийг хэрэглэх энэ тухай үйлчлүүлэгчийн удирдлагадаа нэн даруй мэдэгдэж байх.</p> <p>16. Ээлжийн хугацаанд объектын доторх өрөө, тасалгаа, анги, танхимд цахилгаан, дулаан болон бусад чиглэлийн гэмтэл доголдол гарсан үед анхан шатны арга хэмжээ авч, дараах мэдээллийг түргэн шуурхай холбогдох албан тушаалтанд мэдээлж өндөр хараа хяналтын дор үйл ажиллагаа явуулна.</p> <p>17. Ээлжийн хугацаанд ажлын цаг тарснаас хойш анги танхим, өрөө тасалгааны гэрлийг хариуцсан ажилтнаар унтраалгах шаардлага тавих, коридорын гэрлийг унтрааж гэрэл цахилгаан хэмнэхэд санаачилгатай ажиллах.</p> <p>18. Байгууллагын гадна талбайн хэсгийн цэвэрлэгээг хариуцан ажиллах /бороо орсон үед шуудуу татах, цас, хог цэвэрлэх, гадна явган замын цасыг цэвэрлэж байх.</p> <p>19. Боловсролын байгууллагын харуул хамгаалалтаар ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.</p> <p>20. Ажилчид болон оюутан суралцагчтай ёс зүйтэй харьцах.</p> <p>21. Тухайн байгууллагын дүрэм журмын хүрээнд ажиллах.</p> <p>22. Харуул хамгаалалтын компани нь ээлжийн ажилчдыг улирааж гаргахгүй байх</p>
--	--	---

Техникийн тодорхойлолт гаргасан ЗАА дарга-менежер



У.Раднаабазар

Г.Амарсанаа